



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар A/191


Ховд

Г Т
Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


- Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд чанарын менежментийн ISO 9001 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цэвэрлэгээ үйлчилгээ хийх журам”-ыг 1 дүгээр, “Машин техникийн үзлэг оношлогоо хийх журам”-ыг 2 дугаар, “Харуул хамгаалалтын журам”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Журам батлагдсан талаар ажилтнуудад мэдээлэл өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч бөгөөд Санхүү, аж ахуйн албаны дарга Б.Нямдэлгэр, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний албаны нягтлан бодогч Б.Энхмандал нарт даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02 00961
D/Tush-A/191-Da



Аймгийн Засаг даргын Тамгын газрын
2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
A/191 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт

МАШИН ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ОНОШИЛГОО ХИЙХ ЖУРАМ

Энэ журмын зорилго нь байгууллагын үйлчилгээний машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Машин техникийг өглөө ажил гүйцэтгэхэд бэлэн эсэхийг шалгаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг үйлчилгээний ажилтан жолоочид өгнө.

Жолооч бүр техникийн үйлчилгээний дэвтэртэй байх бөгөөд техникийн үйлчилгээний дэвтэрт уг автомашинд хэзээ, ямар аж ахуйн нэгжээс ямар сэлбэг хэрэгсэл, тос масло авч сольсон талаар тэмдэглэж бичнэ.

1. Байгууллагын эрх, үүрэг

- 1.1. Жолоочийн машин техникт хэрэгтэй багаж тоног төхөөрөмжийг авч өгөх
- 1.2. Машин техникийг үзлэг оношилгоонд цаг тухай бүрт нь оруулах
- 1.3. Жолоочийг машин техникийн бүрэн бүтэн байлгахыг шаардах
- 1.4. Автомашин бүрт техникийн үйлчилгээний дэвтэр нээж, хөтлүүлэх

2. Жолоочийн эрх үүрэг

2.1. Байгууллагыг машин техникийг үзлэг оношлогоонд цаг хугацаанд нь оруулж өгөхийг шаардах

2.2. Өөрийн буруутай үйл ажиллагаанаас бусад машин техникийн эвдрэл гэмтэл болон засвар үйлчилгээ хийлгэхийг байгууллагын удирдлагаас шаардах

2.3. Жолооч нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж ажиллана.

2.4. Жолооч өглөө ажилд гаражын өмнө масло, усны түвшинг үзсэний дараа хөдөлгүүрээ асааж бүх гэрлэн дохио, жолооны хурд, толь, тормозоо шалгах.

2.5. Жолооч бүр техникийн үйлчилгээний дэвтрийн тухай бүр үнэн зөв хөтлөх

2.6. Заагдсан маршрут, объектод хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх

2.7. Хурдыг дүрэмд заасны дагуу тохируулж явах.

2.8. Халтиргаатай, үзэгдэх талбай хязгаарлагдмал үед анхаарал болгоомжтой явах, хурд, хоорондын зайл дүрэмд заасаны дагуу тохируулж явах

2.9. Ажил дууссаны дараа машины бүрэн бүтэн байдлыг манаачид хүлээлгэн өгөх.

2.10. Авто машинд гагнуур хийхдээ мэргэжлийн засварын газарт гагнуур хийлгэх.

3. Жолоочид хориглох зүйл

3.1. Засвар хийхдээ тохирсон зориулалтын багаж түлхүүрийг хэрэглэхээс гадна гэмтэлтэй багаж хэрэглэхийг хориглоно.

3.2. Өвлийн цагт моторыг гэсгээх шаардлагатай тохиолдолд ил галаар галлахыг хориглоно.

3.3. Бусдын техникийг зөвшөөрөлгүй жолоодохыг хориглоно.